

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2020.02.14, №06 (135)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№515

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ДУНДАЖ
ДАВХАРГА
ГООЖИЖ БАЙНА



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр
Ph.D /Боловсрол судлал/

Ажил мэргэжлийн
ЧИГ БАРИМЖАА

IV НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ НАМРЫН
ЧУУЛГАНААР
БАТАЛСАН 154 ХУУЛЬ

➤ УТААГ 50 ХУВЬ
БУУРУУЛСАН ГЭЖ
ҮНЭН ҮҮ?

VI НҮҮРТ



Ардчилсан нийгэмд сонгосон төрдөө хяналт тавьж, хариуцлага нэхдэг, хамгийн идэвхтэй иргэд нь дундаж давхаргынхан. Дундаж давхарга том байх тусмаа боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээ хүртээмжтэй, төр засгийн албан тушаалтнуудын авлига, хээл хахууль харьцангуй бага байдаг. Тэгвэл дундаж давхарга нь нийгмийн олонх болоогүй, хэт өндөр ба хэт доогуур орлоготой хэсгийн зааг, ялгаа өссөн улс оронд нийгэм нь улам бүр талцан хуваагдаж, зөрчил тэмцэл хурцаддаг.

Сүүлийн хэдэн арван жилд, аж үйлдвэржилт өндөр хөгжсөн орнуудаас хөгжиж буй орнуудад шилжиж, хятадын эдийн засгийн эрчимтэй өсөлтийн нөлөөгөөр бүс нутгийн орнуудын эдийн засаг ч тогтвортой өсөв. Улс орны эдийн засаг өсөхийн хэрээр хамгийн гол хэрэглэгчид нь болох дундаж давхарга тэлж, улмаар зах зээл өргөжиж, төрөлжихийн зэрэгцээ шинэ бүтээл төрж, шинэ ажлын байр олноор бий болдог. Мөн хөрөнгө оруулалт, хуримтлал нэмэгдэх нөхцөл бүрддэг учир энэ давхарга эдийн засгийн өсөлтийг тэтгэх гол хүчин зүйл нь юм. ▶▶

The Defacto Gazette

НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

ДУНДАЖ ДАВХАРГА ГЭЖ ХЭН БЭ?

Эдийн засагчид нийгмийн хөгжилд дундаж давхаргын үүрэг, оролцоог чухалчилж ирсэн ч өнөөг хүртэл “дундаж давхарга” гэж яг хэнийг хэлэх вэ гэдэг дээр нэгдсэн ойлголт, зөвшилцөлд хүрээгүй ажээ.

Жишээ нь, Brookings Institution өдөрт 11-110 ам.долларын орлоготой хүнийг дундаж давхаргынх гээд 2016 оны байдлаар дэлхийн 3.2 тэрбум хүн энэ бүлэгт хамрагдаж, жил бүр 140 сая хүнээр нэмэгдэж байна гэжээ.

Өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, өөр нэг тодорхойлолт бол дундаж давхарга нь хоол, хувцас, орон гэр, боловсрол, эрүүл мэндийн сар тутмын зардлаа төлөөд цаана нь тодорхой хэмжээний хуримтлал хийж чадаж буй айл өрхийг хэлдэг.


Өндөр хөгжсөн орны дунджаас доогуур орлоготой иргэн, хөгжиж буй орны дундаж орлоготой иргэнээс харьцангуй өндөр орлоготой. Гэхдээ нэг өдөрт шаардлагатай амьжиргааны түвшин буюу ядуурлын босгыг хүний 1.90 ам.доллар гэдэг мөнгөөр ч бас тооцож байна. Зарим судлаачид хөгжиж буй орнуудын дундаж давхарга гэдэгт өдөрт хүний 2-13 ам.доллар, зарим нь

2-10 ам.доллар, гурав дахь нь 10-100 ам.доллараар тооцохыг зөвлөж байна.

МУ-ын хувьд Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI)-ээс дундаж давхаргыг тодорхойлох судалгааг 2014, 2016 онуудад хийжээ. Уг судалгаанд тухайн жилийн өрхийн дунд (медиан) орлогын 67-200 хувьтай тэнцэх орлоготой өрхийг дундаж давхаргад тооцжээ. Судалгаагаар 2002 онд нийт өрхийн 20 хувийг өндөр, 51 хувийг дундаж, 29 хувийг бага орлоготой өрхүүд бүрдүүлж байсан бол 2014 онд нийт өрхийн 14 хувийг өндөр, 61 хувийг дундаж, 25 хувийг бага орлоготой өрхүүд эзлэх болжээ. Манай дундаж орлоготой өрхийн тоо 12 жилийн дотор 10 хувиар нэмэгдэв.

Мөн өрхүүдийн орлогын тэгш бус байдал хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлжээ. 2002-2008 оны хооронд дундаж орлоготой өрхийн тоо нэмэгдэж, өндөр орлоготой өрхийн тоо буурсан ч орлого нь хэвээр байв. Харин 2008-2014 оны хооронд дундаж орлоготой өрхийн тоо эрс нэмэгдэхтэй зэрэгцээд өрхийн орлого ч нэмэгдсэн бол, өндөр орлоготой өрхийн тоо буурахын хэрээр орлого ч бас буурчээ.

Зураг 1: Дундаж давхаргын өрхөд эзлэх хувь ба орлогод эзлэх хувь



Эх сурвалж: ERI


Мөн өрхийн орлогын тэгш бус байдал зөвхөн хот хөдөөд бус, нийслэлийн дүүрэг хооронд ч байна. Бага орлоготой өрхийн тоо нийслэлийн төв рүү ойр дүүргүүдэд захын дүүргүүдээс харьцангуй цөөн байна.

Засгийн газар хаврын чуулганаар хэлэлцүүлэх ирэх 30 жилийн хөгжлийн төлөвлөгөөндөө “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэх болно” гэсэн том зорилтыг дэвшүүлээд байна. Энэ баримт бичигт дундаж давхаргыг өнөөдөр 16.2 хувь гээд 2030 онд 50, 2040 онд 70, 2050 онд 80 хувьд хүргэх гэнэ. Энэ 16.2 болон бусад хувийг хэрхэн тооцсон нь ойлгомжгүй байна.

- Дундаж давхаргыг орлогоос нь гадна боловсролын түвшингээр тодорхойлох хандлага ажиглагдаж байна. Учир нь нийгмийн боловсролтой хэсэг нь улс төр, эдийн засгийн шийдвэр гаргахдаа илүү нухацтай хандаж чаддаг. Тэд өөрсдийг нь ижил тэгш, эрхтэй, (dignity) адилхан хүн гэдгээр нь хандахыг бүхнээс түүрүүнд төрөөс шаарддаг. Юугаар ч хэмжсэн нийгмийн дундаж давхарга наад зах нь ажилтай, орон байртай, тогтмол орлоготой, хуримтлалтай байхыг хэлнэ.

Дундаж давхарга бол нийгмийн тогтвортой байдлын үндэс. Тэгвэл эдүгээ МУ-д чанартай дундаж давхарга бүрдэхийн оронд иргэд боломжтой л бол гадаадад ямар нэг аргаар гарахыг зорих боллоо. Гадаадад сурах, ажиллах, аялахаар явж байгаа хүмүүсийн тоо эрс нэмэгдэхийн зэрэгцээ, ялангуяа гадаадад байнга оршин суугчдын тоо жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Зураг 2. Гадаадад байнга оршин суугчдын тоо, жил тус бүрээр



Эх сурвалж: УСХ, 2020

Сүүлийн арван жилийн байдлаар 2015 онд хамгийн бага буюу 6768, 2019 онд хамгийн их буюу 19470 хүн гадаадад амьдрах болжээ. Гадаадад нийт 200 орчим мянган (ГХЯ-ны Консулын газар) иргэн амьдарч буйн 120 мянга нь тэнд оршин суухаар явсан гэсэн үг. Монголд ажилтай атлаа цалин нь амьдралын наад захын суурь зардлаа ч төлж хүрдэггүй, тэгээд бүх насаараа ажиллаж, тушаасан тэтгэвэр нь хоногийн хоолоо даахгүй болсон учир иргэд хөлөөрөө сонголт хийж байна. Энэ бол манай дундаж давхарга “гоожиж” байна гэсэн үг.

Гол шалтгааныг томосгож харвал, МУ-ын өнөөгийн улс төр, эдийн засгийн тогтолцоо нь дундаж давхаргын өрхийн сайхан амьдрах боломжийг ховх сорж, маргаашийн итгэлийг нь үгүй хийж байгаатай холбоотой. Улс төрийн олигархижсан, клиентелизмд идэгдсэн тогтолцооноос иргэд зугтаж байгаа хэрэг. Ихэнх нь сурсан, мэдсэнээ орхиод Солонгос, Австрали зэрэг хөгжилтэй орнуудад биеийн хүчний, хар ажил хийх нь Монголоос илүү орлоготой, бас нэр хүндтэй болсон гэсэн үг.

Дундаж давхаргын бууралтыг зогсоохын тулд юуны өмнө, улс төрийн клиентелист тогтолцоогоо халах шаардлагатай байна. Дараа нь боловсролын тогтолцоогоо эрс сайжруулах, шинэ түвшинд гаргах шаардлагатай юм. Монголын төр засаг сүүлийн үед элит боловсролыг шүтэх боллоо. Дэлхийн топ 100 их сургуульд тэнцсэн оюутнуудад тэтгэлэг олгох, хувийн, өндөр төлбөртэй дунд сургуульд хувьсах зардал өгөх гэх мэтээр. Харвард, Стэнфордод хоёр, гурван хүүхэд сургаснаас хотын захын дунд сургуулийн 200, 300 хүүхдийг 50 биш ядаж 25 сурагчтай ангид сургасан нь урт хугацаандаа илүү өгөөжтэй юм. Тиймээс дээрх нийгмийн тэгш бус байдлыг хөөрөгдсөн бодлогоо зогсоож, урт хугацаанд эдийн засгийн хүртээмжтэй өсөлт, хариуцлагатай ардчилсан улс төрийн тогтолцоог бэхжүүлэхэд гол нөлөө үзүүлэх нийтийн боловсролыг дээшлүүлэх нь чухал юм аа.



НИЙТЛЭЛ

Б.НАСАНБАЯР

Ph.D /Боловсрол судлал/

Ажил мэргэжлийн ЧИГ БАРИМЖАА

Ажил мэргэжлийн чиг баримжаа гэдэг нь хувь хүний амьдралын туршид хийж гүйцэтгэсэн ажил мэргэжил болон суралцахуйг илэрхийлсэн нэр томъёо юм. Өнгөц харахад энэ нь энгийн, хүн бүр мэдэх юм шиг хэдий ч үнэн хэрэгтээ нарийн төвөгтэй ойлголт байсаар иржээ. 1977 онд ажил мэргэжлийн боловсрол судлаач Ватц “ажил мэргэжил нь хүний албан болон албан бус боловсролын зарчмаар сурсан сургалт бас цалинтай, цалингүй хийсэн бүх ажлын насан туршийн хөгжил дэвшил юм” гэж тодорхойлсон байдаг.

“Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” суралцахуй гэдэг нь “суралцагчдын хөгжлийн тодорхой үе шат бүрт тохирсон мэдлэг, чадвар, хандлагыг сургалтын хөтөлбөрт тусган, ажил мэргэжилтэй холбоотой ухаалаг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, үйл хэрэг болгон хөгжүүлдэг” үйл явц юм. Ажил мэргэжлийн чиг баримжааг тодорхойлох нарийн төвөгтэй үзэгдэл, үйл явцыг тодорхойлсон эрдэмтэн судлаачдын баталсан Зан төлөвийн хүчин зүйлийн онол, Хөгжлийн онол, Нийгэм танин мэдэхүйн онол, Системийн онол, Каосын онол гэсэн үзэл баримтлалууд өнөөг хүртэл хөгжиж иржээ. Эдгээр онолуудын нотолсноор ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмших үйл явц өөрийн гэсэн хөгжлийн үе шаттай байдаг ажээ.

Гинсберг (1951), Доналд Супер (1990) нарын дэвшүүлсэн Хөгжлийн онол нь ажил мэргэжлийн чиг баримжаа төлөвших үйл явцыг хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн үе шаттай холбон тодорхойлсон. Энэ онолд ажил мэргэжлийн чиг баримжааны үе шатууд нь суралцагчдын бага, дунд, ахлах сургууль болон сургууль төгссөний дараах насны онцлогоос хамаардаг учир тухайн үе тус бүрт тохирсон суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг.

Хөгжлийн онолоор ажил мэргэжлийн чиг баримжаа төлөвшлийг “11 орчим насны хүүхэд тоглодог тоглоом, дуртай зүйлээрээ дамжуулан мөрөөдлийн, 13 орчим насны хүүхэд өөрийн чадвар, давуу талаа мэдэрсэн, 15-16 насны хүүхэд өөрийн зорилго, үнэт зүйлийг илүүд үзсэн, 17-18 насандаа ирээдүйн төлөвлөлтийг харгалзахыг хичээсэн” үе хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл хүүхдийн сэтгэлгээ, танин мэдэхүйн хөгжлийн үе шаттай ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмших хөгжлийн үе шат маш нягт уялдах учиртай ажээ. Уялдуулан хөгжүүлээгүй тохиолдолд тодорхой нэг үе шатанд “гацах” хандлага их байдаг байна. Тиймээс суралцагчдыг танин мэдэхүйн хөгжлийн үе шатны дагуу суралцах үйл явцад чиглүүлэх нь тэднийг ажил мэргэжлээ илүү бодит, ухаалаг сонголт хийх чадварт дадлагажуулдаг.

ОЛОН УЛС БОЛОН МОНГОЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

АНУ ерөнхий боловсролын сургуульд бага ангиас эхлэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг хамгийн сайн хэрэгжүүлдэг улс орнуудын нэг юм. Дэлхийн олон орон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг хэрэгжүүлэхдээ АНУ-ын бэлтгэн гаргасан материалыг хэрэглэх нь түгээмэл байдаг байна.

АНУ, Канад, Их Британи, Шинэ Зеланд, Австрали, Өмнөд Солонгос, Сингапур, Япон зэрэг орнуудын хөтөлбөрийг судлаж үзэхэд засгийн газар, яам нь ажил мэргэжлийн

чиг баримжаа олгох сургалтын талаар тодорхой бодлого, хөтөлбөртэй зарим нь бие даасан хичээл, багштай байдаг бол нөгөө хэсэг нь тодорхой хичээлийн агуулгын хүрээнд багтаан хүүхэд бүр судлахаар баталсан байна. Эдгээр орнуудад тус хичээлээр суралцагчдыг өөрийгөө танин мэдэх, хичээл сургалтыг өөрийн эзэмших боловсрол, ажил мэргэжлийн боломжуудтай холбон ойлгох, хөдөлмөрийн зах зээлд шинээр бий болж байгаа ажил мэргэжилтэй танилцах болон насан туршдаа сурч боловсрох дадал чадварыг эзэмших боломж олгодог байна.

Японулс 1949 онд Боловсролын сайд нь дунд сургуулийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр батлан одоог хүртэл бие даасан хичээл болон сургалтыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж иржээ. Тус хичээлийг

1. ажил мэргэжлийн төлөвлөлт хийх
2. ажил мэргэжлийн мэдээлэл цуглуулах, хэрэглэх
3. шийдвэр гаргах
4. хүмүүстэй харилцах гэсэн 4 чиглэлийн хүрээнд 12 чадвар эзэмшүүлэхээр бага, дунд, ахлах ангийн түвшинд хэрэгжүүлж байна.

Жишээ нь, “Хүмүүстэй харилцах” гэсэн чиглэлийн хүрээнд:

- ✓ Бага ангид: “өөрийнхөө талаар ойлгох болон бусдыг хүндлэхийн ач холбогдлыг мэдэх, өөрийн бодол санаа хэрхэн өөрчлөгддөг яагаад энэ нь чухал болохыг ойлгох”
- ✓ Дунд ангид: “өөрийнхөө хүчтэй талыг мэдэж, бусдад хэрхэн нөлөөлж болох талаар ойлгож мэдэх, өөрийн бодол, санааны өөрчлөлтийг ойлгож мэдэх, энэ нь яагаад чухал болохыг ухамсарлах, хүмүүстэй харилцаа тогтоох”
- ✓ Ахлах ангид: “өөрийнхөө хүчтэй талыг ойлгох, өөрийн зан төлөв нөлөөлөл болон ажил мэргэжлийн холбоо хамаарлыг таньж мэдэх, өөрийн бодол, санааны өөрчлөлтийг ойлгож мэдэх, энэ нь яагаад чухал болохыг ухамсарлах, бусадтай үр дүнтэй харилцах чадвар эзэмших” гэж тус тус тодорхойлсон байна.

2013 онд МУБИС-ийн судлаачдын хийсэн судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан нийт

багшийн 88.7%, суралцагчдын 80% нь сургуульд нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төв байдаггүй, тогтмол хуваарийн дагуу энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаггүй гэсэн байна. Ихэнх сургуулийн менежмент, үйл ажиллагааны төлөвлөлтөнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэл, цөөн хэдэн сургуулийг эс тооцвол огт байхгүй байна. Суралцагчдын 66% нь ажил мэргэжлийн чиг баримжааны мэдээллийг эцэг эх, ах дүү найз нөхдөөсөө авдаг гэж хариулсан.

Тус судалгаанаас харахад багш, сурагч, эцэг эх, удирдлагууд элсэлтийн ерөнхий шалгалтын хичээл яаж сонгох, ямар шалгалт өгөх, шалгалтын тест дээр хэрхэн ажиллах талаар зөвлөгөө, лекц сургалтыг “ажил мэргэжлийн чиг баримжаа” олгох үйл ажиллагаа гэж ташаа ойлгож байна. Мөн судалгаанд хамрагдсан боловсролын салбарын ихэнх хүмүүс гар урлал хийх, ногоо тарих, жолооны курс, үс засах гэх мэт мэргэжлийн сургалтыг “ажил мэргэжлийн чиг баримжаа” олгох үйл ажиллагаа гэсэн буруу ойлголттой байгаа нь энэ чиглэлээр хийх ажил их байгааг илэрхийлж байна.

2015 оноос цөм хөтөлбөрийн хүрээнд “ажил мэргэжлийн чиг баримжаа” олгох хичээлийг 8-р ангиас “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа”-ны цагийн хүрээнд орохоор бэлтгэл, судалгаа хийж, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагад зориулсан зөвлөмж боловсруулан хүргэж, 20 гаруй мянган сурагчдын хүрээнд асуулга судалгаа хийгдсэн байв. Гэвч тус хичээлийг шаардлагагүй гэж үзсэн үү? эсвэл ойлгоогүй юу? ямар ч гэсэн одоогийн БСШУС-ын сайд нь сургалтын төлөвлөгөөнөөс хасч орхисон. Хэрэв бид хүүхэд, залуу үеэ бүтээлч, сайн сайхан, амжилттай ажиллаж, амьдраасай гэж хүсч байгаа бол “ажил мэргэжлийн чиг баримжаа” олгох сургалт, үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлэх шаардлага гарцаагүй байна.

2020 оны 2-р сар

“ЭРХ ЧӨЛӨӨ”

ГУРВАЛ НОМ

Интерном номын дэлгүүрийн бүх салбаруудаар худалдаалагдаж байна.



+(976) 9410 9342



ДеФакто ТОЙМ

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2020.02.09-ний дугаар
Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

НАМРЫН ЧУУЛГАНААР БАТАЛСАН 154 ХУУЛЬ

УИХ-ын намрын ээлжит чуулган өнгөрсөн долоо хоногт өндөрлөлөө. Өнгөрсөн оны 3-р сараас хойш завсарлалгүй 11 сарын турш ажилласан байна. Манай улсын түүхэнд ингэж үргэлжилж хуралдсан тохиолдол байгаагүйг УИХ-ын дарга Г.Занданшатар чуулган хаах үеэр онцлов. Энэ хугацаанд чуулган 86 өдөр үргэлжилсэн. Нэгдсэн хуралдаан 32 удаа, бусад хороод давхардсан тоогоор 119 удаа хуралдаж, нийт 154 хууль тогтоомж баталжээ. Онцлогоос нь дурдвал:

- ♦ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өнгөрсөн оны 7-р сараас хойш хэлэлцэж баталсан
- ♦ Оюу толгойн гэрээ, хэлэлцээрүүдийг шалгах ажлын хэсэг байгуулж, улмаар гэрээг сайжруулах тогтоол баталсан
- ♦ Засгийн газрын тусгай сангуудын хуулийг өөрчилсөн
- ♦ Өмнө нь 1 сонгуулийн хуулиар УИХ, Ерөнхийлөгч, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохицуулсан хуультай байсан. Харин өнгөрсөн 12-р сард өөрчилж тусдаа 3 сонгуулийн хуультай болсон. Улсын их хурлын ээлжит сонгууль 6-р сарын 24-нд болно

Хуулийн тухай хууль гэж бий. Аливаа нэгэн хууль гарахаасаа өмнө хараат бус судалгаа хийгдэж, түүндээ үндэслэсэн байх ёстой юм л даа. Гэтэл 2016 оноос хойш их хурлын чуулганыг дүгнэхдээ (хууль батлах) ямар судалгаан дээр суурилсан тухай ерөөсөө ярихаа больсон. Тийм ч учраас хуулиудад үргэлж өөрчлөлт орсон хэвээрээ л байгаа.



Хуулийн засаглал өндөр хөгжсөн орнуудад Regulatory impact assessment (RIA) буюу хууль журмуудын нөлөөний үнэлгээ гэж хийгддэг. Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын урилгаар энэ чиглэлийн олон улсын хэмжээний туршлагатай мэргэжилтэн Монтин гэж хүн өнгөрсөн 12-р сард ирсэн. Ноён Монтинтой Дефакто ярилцлага хийсэн ба тэрээр аливаа нэгэн хууль журам шинээр гарахдаа өөр ямар хууль журамд нөлөөлөх юм бэ? Нэг шинэ хууль нэмэгдэж байгаа бол аль нэг хуулийг хасаж болох уу? зэргийг заавал судалсан байх хэрэгтэй гэж зөвлөж байсан. Ийм хараат бус үнэлгээ дүгнэлт хийх цаг ирчихээд байна. Энэ байхгүй учраас монголын хуулиуд батлагдан гарсныхаа дараа алаг эрээн болтлоо өөрчлөгдөж байгаа юм. Хуулиа судалгаатай гаргаач ээ, эрх баригчид аа.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn

УТААГ 50 ХУВЬ БУУРУУЛСАН ГЭЖ ҮНЭН ҮҮ?


УИХ-ын намрын ээлжит чуулган хаасантай холбогдуулан харьяалах байнгын хороо, түр хороо, дэд хороо энэ хугацаанд хийсэн ажлаа тайлагналаа. Энэ хүрээнд УИХ-ын Өргөдлийн байнгын хороо ажлаа тайлагнах үеэр тус хорооны дарга буюу Агаарын бохирдлыг бууруулах ажлын хэсгийн ахлагч М.Оюунчимэг нэг жилийн дотор 75 тэрбум төгрөгийг зарцуулж агаарын бохирдлыг 50 хувь бууруулсан гэж мэдэгдсэн.

У.Хүрэлсүхийн Засгийн газар УБ хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон. Оронд нь сайжруулсан шахмал түлшийг гэр хорооллын иргэдэд нийлүүлсэн. Энэ шийдвэрийн үр дүнд нийслэлийн хорт утаа багассан нь хонгилын үзүүрт гэрэл харагдуулав. Харагдах хэсэг нь илт буурсан ч, агаар дахь тоосонцор, хүхэрлэг хийн хэмжээг бууруулах ажил үлдэж байгаа. Ер нь бол 75 тэрбум төгрөгөөр утаагаа 50 хувь бууруулсан гэж өөрсдөө дүгнэж байгаа юм байна. Гэхдээ үүнийг хараат бус судалгааны байгууллагаар дүгнүүлэх хэрэгтэй. Ямар нэгэн хэмжигдэхүйц тоо баримтаар ярьсан нь дээр.

М.Оюунчимэг агаарын бохирдлыг бууруулахаар 750 тэрбум төгрөгийг сүүлийн 10 жилд салхинд хийсгэсэн. Үр дүнд нь агаар, хөрсний бохирдол дээд




цэгтээ хүрээд байгааг баримт нотолгоотой нь гаргаж, хуулийн байгууллагад шилжүүлсэн гэж мэдэгдсэн. Энэ их ноцтой мэдээлэл. Нийтийн хөрөнгийг дээгүүрээ завшиж байхад, олон мянган хүүхэд, нярай хорт утаанд хордож үрэгдсэн шүү дээ. Гэтэл яахаараа агаарын бохирдлыг бууруулна гэсэн 750 тэрбум төгрөгийг төр засаг нь найрлаад, хулгайлаад, хуваагаад идчихсэн байсныг бид 10 жилийн дараа мэдэж байгаа юм бэ? Одоо хуулийн байгууллага хэн, хэн хэрхэн идсэн гэдгийг нийтэд ил тод мэдэгдэх ёстой. Иргэд үүнд хариуцлага нэхнэ, энэ сонгуулиар.



Эдгээр зургийг 2-р сарын 8-ны өглөө 11 цагт авав.

ХӨДӨЛГҮҮРИЙН МӨНХИЙН ҮС



**TOTAL QUARTZ 9000
5W-40**



**ДОКТОР АВТО СҮЛЖЭЭ
ДЭЛГҮҮРИЙН БҮХ САЛБАРААР
ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ.**

Холбоо барих утас: 9411-7143, 9906-6402

 www.minesup.mn

 @TOTALMongolia

 fb.com/TOTALMongolia

 @TOTALMongolia

Албан Ёсны Дистрибьютор:

UP
MINES
www.minesup.mn